

Бүртгэв.

Чингэлтэй дүүргийн засаг

даргын тамгын газар
2022 оны 02 сарын 12-ны өдөр

ХАМТЫН ГЭРЭЭ



2022 оны сарынны өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг үндэслэн нэг талаас “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК /цаашид А тал гэх/, нөгөө талаас “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Үйлдвэрчний Эвлэлийн Хороо /цаашид Б тал гэх/ харилцан тохиролцож, энэхүү Хамтын гэрээ /цаашид энэхүү гэрээ гэх/-г байгуулав.

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХКомпани дахь хөдөлмөрийн харилцаа, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулах, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлж баталгаажуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг зохицуулах эрх зүйн баримт бичиг мөн.

1.2. Талууд харилцан ойлголцох, бие биеэ хүндэтгэн, эрх тэгш байх, тохиролцсон заалтуудыг хүрсэн түвшнээс дордуулахгүй байх зарчмыг баримтлан хамтран ажиллана.

1.3. Энэхүү гэрээ нь компанийн харъяалал, өмчлөл, удирдлагын бүтэц өөрчлөгдөхөд хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

1.4. Үйлдвэрчний Эвлэлийн гишүүд болон ажилтнуудаас гарсан санал санаачлагыг үндэслэн харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

1.5. Энэхүү гэрээ нь оролцогч талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж хөдөлмөрийн тухай хуулийн 31.3-т заасаны дагуу 3 жилийн хугацаатай мөрдөж ажиллана.

1.6. Энэхүү гэрээний бэлтгэл ажлыг зохион байгуулах, батлах, бүртгүүлэх, харъяа аймаг, дүүргийн газарт хүргэх үүргийг А тал, Үйлдвэрчний эвлэлийн Улаанбаатар хот, аймаг, дүүргийн салбар хороодод хүргэх үүргийг Б тал хүлээнэ.

1.7. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, оролцогч талууд тус бүр нэг хувийг авч хадгална.

ХОЁР. “А” ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Хөдөлмөрийн сахилга бат, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийнхээ хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний гарсан шалтгааныг судалж, багасгах талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулна.



2.2. Ажилтны тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажлын байранд байнга ашиглаж хэвшүүлэхэд хяналт тавьж, гарсан зөрчил бүрд нөлөөллийн арга хэмжээ авч, үр дүнд хүргэнэ.

2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн чиглэлээр хуульд нийцүүлж дүрэм, журам гаргах эрхтэй.

2.4 Түншлэлийн хүрээнд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхтэй.

ГУРАВ. "Б" ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Б тал өөрийн эрхээ Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд Хамтын гэрээтэй холбогдох асуудлыг А талтай гэрээ, хэлэлцээр хийх, зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

3.2. Үйлдвэрчний эвлэлийн гишүүдэд ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэхэд нь зөвлөгөө өгч, хөдөлмөрийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, зөрчигдсэн эрхийг нь хамгаална.

3.3.Б тал ажилтанд компанийн эрхэм зорилго, зорилтыг ухамсарлан, ёс зүйтэй, өөрийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэн ажиллахад нөлөөлж ажиллана.

3.4. Ажилтны үндсэн цалингийн сүлжээ, цалин хөлс, шагнал, урамшууллын талаарх асуудал болон дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулахад санал оруулж болно.

ДӨРӨВ. НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

4.1. Ажилтнуудын хүсэлтийг харгалзан 1 сарын цалинг урьдчилан олгож болно.

4.2. Ажилтнуудын нийгмийн асуудлыг тухайн жилийн батлагдсан эх үүсвэрийн хэмжээнд орон байрны нөхцөл сайжруулахад 550 сая төгрөгөөс доошгүй хөрөнгө зарцуулна.

4.3. Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтанд компанид ажилласан жилийг харгалзан 2-12 сарын дундаж цалинтай тэнцэх тэтгэмжийг нэг удаа олгоно. Мэдээлэл, харилцаа, холбооны салбарын бүтцийн өөрчлөлтөөр Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн харъяалалд Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв, Монголын цахилгаан холбоо ХК-аас шилжин ирсэн болон тус байгууллагуудын өмнөх бүтцэд ажиллаж байсан ажилтнуудын ажилласан хугацааг хамааруулан тооцно. Үүнд:

- Ажилтан 3-6 жил ажилласан бол 2 сар
- Ажилтан 7-11 жил ажилласан бол 4 сар
- Ажилтан 12-18 жил ажилласан бол 6 сар
- Ажилтан 19-25 жил ажилласан бол 9 сар
- Ажилтан 26-с дээш жил ажилласан бол 12 сар

4.4. Ажилтан цэргийн жинхэнэ албанд татагдсан бол ажлын байрыг хадгалах ба 2 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

4.5. Ажилтны эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн тухайн ажлын байрандаа тэнцэхгүй болсоныг тухайн ажилтантай зөвшилцөн өөр ажлын байранд шилжүүлэн ажиллуулж болох эсэхийг зөвшилцөн шийдвэрлэнэ.

ИТЭ
ХА
ГЭ
ЭЛ
БҮР

ТАВ. ЦАЛИН ХӨЛС

5.1. Ажилтанд цалин хөлсийг сард хоёр удаа /урьдчилгааг тухайн сарын 10-нд, сүүлийн цалинг 25-нд/ мөнгөн хэлбэрээр олгоно.

5.2. Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд цалин хөлсийг компанийн ашиг орлогод харгалзан ажилтнуудын үндсэн цалинг тогтмол нэмэгдүүлэх бодлого баримтална.

5.3. Ажилтан хуанлийн 30 хоногоос дээш хугацаагаар эзгүй байгаа ажилтныг орлон буюу хавсран гүйцэтгэн ажилласан бол үндсэн цалингийн 50 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно.

5.4. Мэдээлэл холбооны сүлжээ компанид ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор "удаан жил ажилласны цалингийн нэмэгдэл"-ийг олгоно. Удаан жил ажилласны цалингийн нэмэгдлийг ажилтны сарын үндсэн цалингаас 3-5 хувиар сар бүр тооцож олгоно. Сахилгын шийтгэл авсан ажилтанд тухайн жилд олгохгүй.

5.5. Техник, технологийн шинэчлэл, ажлын байрны ачаалал зэргээс шалтгаалан хууль тогтоомжийн хүрээнд сул зогсолт хийж болох ба ажилтнаас шалтгаалахгүйгээр гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлээгүй нөхцөлд үндсэн цалингийн 80%-иас доошгүй хэмжээний олговрыг олгоно.

5.6. Монгол улсын зөвлөх инженер, мэргэшсэн нягтлан бодогч нарт үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл олгоно.

5.7. Шөнийн цагаар ажилласан ажилтанд цаг тутамд 500 төгрөгийн нэмэгдэл хөлс олгоно.

5.8. 5.7 заалт зөвхөн ээлжийн графикаар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан хамрагдана.

5.9. Компанийн үндсэн ажилтанд ажилласан өдрөөр тооцон Улаанбаатар хотод 6000 төгрөг, Багануур, Налайх дүүрэг болон Дархан-Уул, Орхон аймагт 5000 төгрөг, бусад аймгийн төвд 4500 төгрөг, сумын төвд 3000 төгрөгийн хоол унааны мөнгийг олгоно.

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд байгууллагын эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний 1,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг зарцуулна.

6.2. Нийт ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтыг жилд хоёроос доошгүй удаа нийт ажилтныг хамруулж зохион байгуулна.

6.3. Ажилтныг шаардлагатай ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангана. /Өвлийн хувцсыг 11-р сарын 01, зуны хувцсыг 5-р сарын 01-ны дотор олгоно/

6.4. Шаардлагатай тохиолдолд хугацаанаасаа өмнө ашиглах боломжгүй болсон ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэлтэс, тухайн газрын ажлын зөвлөлтэй хамтран байгуулсан комисс акт тогтоож дахин олгож болно.

6.5. Ажлын байрны эрүүл ахуйн стандартыг мөрдөж цэвэр усаар хангана.

И,
М
РЭ
ЦЭ
ТГ



6.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажиллах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

6.7.Ажил олгогч нь эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргаж, түүний амь нас, эрүүл мэндийн болон хариуцлагын даатгалд даатгуулна.

ДОЛОО. МЭДЛЭГ, МЭРГЭШЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

7.1.Жил бүр сургалтын зардалд тодорхой төсвийг батлуулж, зарцуулна.

7.2.Ажил олгогч тал компанийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, ажилтнуудыг мэргэжил, мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

7.3.Ажилтны мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадварын түвшин тогтоох /аттестатчлал/ шалгалтыг авахдаа 1 сарын өмнө мэдэгдэж /мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломжит хугацаа/ хичээл сургалт явуулсны дараа 2 жилд 1 удаа аттестатчлалыг явуулах ба шалгалтын үр дүнг харгалзан нэмэгдэл олгоно.

7.4.Ажилтнуудаас шалгалт авахдаа тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолт, эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр нь шалгалт авна.

7.5.ИТА-ын сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулахдаа эргэх холбоо үүсгэн давтамжтай зохион байгуулна.

7.6.Тухайн салбар нэгждээ тогтвор суурьшилтай ажиллаж, компанийхаа үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан 55 нас хүрсэн эрэгтэй, 50 нас хүрсэн эмэгтэй түүнээс дээш насны ажилтнуудыг аттестатчлалын шалгалтаас чөлөөлнө.

НАЙМ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЭРХИЙГ ХАНГАХ

8.1.Шаардлагатай үед Үйлдвэрчний эвлэлийн гишүүд, сонгуульт ажилтнуудыг сургалтын байр, танхимаар үнэгүй хангана.

8.2.Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй Үйлдвэрчний эвлэлийн сонгуультнуудыг сонгуульт ажлаа хийх цаг бололцоогоор хангана.

8.3.Үйлдвэрчний эвлэлийн сонгуультнууд болон гишүүдээс Олон улсын болон салбар, орон нутгийн хурал зөвлөгөөнд оролцох, Үйлдвэрчний эвлэлийн сургалт, семинарт хамруулахад салбарын холбооны албан тоотыг үндэслэн ажлаас нь цалинтай чөлөө олгож дэмжлэг үзүүлнэ.

8.4.Үйлдвэрчний Эвлэлийн гишүүдийн татварыг тогтоосон хувь хэмжээгээр цалингаас бэлэн бусаар суутгаж, Үйлдвэрчний эвлэлийн хорооны дансанд дараа сарын 10-ны дотор шилжүүлнэ.

ЕС. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

9.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4.2, 78.1.5, 80.1.1, 80.1.2, 80.1.3 -т аасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажил олгогч 1 сарын өмнө ажилтанд заавал танилцуулна.

9.2.Хөдөлмөрийн тухай хуульд илүү цагаар ажиллуулахыг зөвшөөрснөөс бусад дараах тохиолдолд илүү цагаар ажиллуулж болно. Үүнд:

- Тусгай шийдвэрээр хойшлуулшгүй ажил, үүрэг гүйцэтгэх
- Гэмтэл саатлын үед ажил, үүрэг гүйцэтгэх
- Олон улсын гэрээ хэлэлцээрт заасан ажил, үүрэг гүйцэтгэх

9.3. Шинэ ажлын байр бий болгох тохиолдолд цомхотголд орох магадлалтай ажилтнуудыг авч ажиллуулах зарчмыг баримтална.

9.4. Цар тахал болон бусад халдварт өвчний үед гэрээсээ зайнаас ажилласан ажилтанд цалин хөлсийг нь бүтэн олгоно.

АРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

10.1. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавьж ажиллах бөгөөд үр дүнг хагас жил тутам хамтран дүгнэнэ.

10.2. Үйлдвэрчний эвлэл, түүний сонгуульт ажилтныг үйл ажиллагааг явуулах нөхцөл, бололцоогоор хангана.

10.3. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

10.4. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах сүү, сүүн бүтээгдэхүүн, түүнтэй адилтгах амин дэмийг биет хэлбэрээр олгоно. Б тал нь ажилтныг ажлын байрандаа хор саармагжуулах бүтээгдэхүүнийг тогтмол хэрэглэж хэвшүүлэхэд хяналт тавина.

10.5. Технологийн шинэчлэл, ажилтны ажлын ачаалал зэргийг харгалзан компанийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр оролцогч талууд хуулийн хүрээнд хамтарч ажиллана.

10.6. Компанийн ажилтнуудыг гадаад, дотоодод аялуулах ажлыг оролцогч талууд хамтран зохион байгуулж болно.

10.7. Ажилтны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, олон нийтийн арга хэмжээг 2 тал хамтран зохион байгуулна.

АРВАН НЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

11.1. Энэхүү хамтын гэрээг хуульд заасан журмын дагуу бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцон, жил бүр дүгнэж шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

11.2. Хамтын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө талууд нөгөө талдаа гэрээг цуцлах, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаагүй бол анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцно.

11.3. Хамтын гэрээг аль нэг талын санаачлагаар дангаар цуцлахыг хориглоно.

11.4. Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр нөгөө талдаа мэдэгдэн харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Хамтын гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг талуудын төлөөлөл гарын үсэг зурж, баталгаажуулна.

11.5. Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь бусад аймаг орон нутаг, газар, хэлтэс, тасаг, салбар нэгжүүд нь энэхүү хамтын гэрээнд тусгагдсан заалтуудыг шууд мөрдөнө.

11.6. Хамтын гэрээний төслийг боловсруулах, хэрэгжилтийг шалгах, биелэлт гаргах ажлыг хийх ба үүнд оролцсон хүмүүсийг ажиллах боломжоор хангана.

11.7. Хамтын гэрээний биелэлтэнд гэрээнд оролцогч талууд нь байнгын хяналт тавьж, биелэгдэхгүй байгаа заалтуудыг гарган холбогдох албан тушаалтанд

мэдэгдэх ба Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, санхүүгийн хэлтэс, Компанийн Ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны ажлын хэсэг хагас, бүтэн жилээр биелэлтийг гаргаж хамтарсан комисст танилцуулан салбар нэгжүүдэд мэдээлж байна.

11.8.Хамтын гэрээний биелэлтийг дүгнэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнууд гаргаж өгч, гэрээ байгуулагч талуудын төлөөлөгчдийн хамтарсан хурлаар дүгнэнэ.

11.9.Хамтын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэх явцад гарсан маргаантай асуудлыг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

11.10.Хамтын гэрээг биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг биелүүлээгүй тал хүлээнэ.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1.Энэхүү хамтын гэрээ нь хүчин төгөлдөр болмогц талуудын хооронд байгуулсан 2018 оны 03 - р сарын 28 -ны өдөр байгуулсан Хамтын гэрээ хүчингүй болно.

“МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ” ХХК-ИЙН

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий удирдлагын газрын
Захирал Л.Баярмагнай

Санхүү бүртгэлийн хэлтсийн
Дарга М.Баярсайхан

Техник ашиглалтын хэлтсийн
Дарга Д.Мянганбаатар

Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн
Дарга Б.Батзориг

СТГ-ын эдийн засгийн хэлтсийн
Дарга Т.Амартүвшин



Компанийн АҮЭХорооны
Дарга Н.Оюунбилэг

Компанийн АҮЭХ-ны Хяналтын зөвлөлийн
Дарга Д.Мөнхсүх

Төв аймгийн ҮЭХ-н дарга, АҮЭХ-ны
Тэргүүлэгч П.Мөнх-Оюун

Улаанбаатар хотын сүлжээний газрын ҮЭХ-н
Дарга Б.Мөнхтуяа

Аж ахуй үйлчилгээний хэлтсийн ҮЭХ-н
Дарга Д.Батхүү

ИЙН
ЗАСАГ ДАРГА

[Handwritten signature]